

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 12 сарын 22

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Суурь түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл хувь
1	2	3	4	5	6	7
1	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах	Ажлын төлөвлөгөөг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байх	Ажлын төлөвлөгөөг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.	100%	Газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/28 дугаар тушаалаар "Ёс зүйн зөвлөл"-ийн дүрэм, ажиллах журмыг баталсан. Үүний хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 26-ны өдөр гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын даргаар 8 арга хэмжээний хүрээнд батлуулсан. "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" батлагдсантай холбогдуулан 2023 оны 11 сарын 25-ны өдрийн А/65 дугаар тушаалаар "Ёс зүйн дэд хороо"-г байгуулан, ажиллах журмыг шинэчилсэн.	100%
2	Ажилтнуудыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор дотоодын сургалт зохион байгуулах	Тайлант хугацаанд 3 удаа сургалт зохион байгуулсан байна.	Ажилтнуудыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчил гаргахгүй байх нөхцөл бүрдэнэ.	100%	2.1.Ёс зүйн дэд хорооны гишүүн Ц.Цэндсүрэн Олон нийт, нийгмийн асуудал хариуцсан ажилтантай хамтран байгууллагын инженер техникийн ажилчдад "Инээмсэглэл бэлэглээ" сургалтыг зохион байгуулсан-II улирал 2.2.Жолооч Н.Пүрэв-Очирт нийгмийн сүлжээнд тархсан бичлэгтэй холбоотой асуудлаар дэд хорооны дарга ганцаарчилсан уулзалтыг зохион байгуулж, нийтийн үйлчилгээний соёл, стандартыг мөрдөж ажиллах талаар зөвлөгөө өгсөн. 2.3.Дэд хороо үйлдвэрийн газрын хэмжээнд "Ёс зүйт үйлчилгээ бидний нүүр царай" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 75 ажилтныг хамруулсан. 12 сарын 04.	100%
3	Ажилтнуудыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтад ажилчдыг хамруулна.	Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтад ажилчдыг хамруулсан байна.	Ажилтнуудыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, ёс зүйн зөрчил гаргахгүй байх нөхцөл бүрдэнэ.	100%	2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зөвлөлийн гишүүн Ц.Цэндсүрэн, СХД-ийн замын цагдаагийн албатай хамтран жолооч нарт "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь ёс зүйн төлөвлөсөөс хамаарах тухай" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад тухайн өдөр амарч байсан 46 жолооч хамрагдсан.	100%


1	2	3	4	5	6	7
4	Зорчигч нараас жолооч, шалгагч нарын ёс зүйтэй холбоотой санал асуулга авч дүгнэх	Зорчигч нараас ажилчдын ёс зүйтэй холбоотой санал асуулга авсан байна.	1. Ажилчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлнэ. 2. Байгууллагын гадаад үнэмлэмжийг тодорхойлно	100%	"Нийтийн тээврийн жолооч нарын харилцааны соёл, ёс зүй" сэдэвт түүвэр судалгааг 2 үе шаттай зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, нэг дүгээр шатны түүвэр судалгааг 2023 оны 05 сарын 13-20-ны хооронд нийт 10 чиглэлд зорчиж буй 80 зорчигчдод 20 асуулга бүхий анкет бөглүүлж, анхан шатны мэдээлэл цуглуулсан. 2 дугаар шатны судалгааг 2023 оны 11 сарын 25-28-ны хооронд "нууцлаг худалдан авалтын арга"-аар 8 асуумжын хүрээнд үнэлж, ажиглалт туршилт хэлбэрээр явуулсан. Шугамын үйлчилгээнд ажиллаж байсан 10 чиглэлийн 15 тээврийн хэрэгслийг хамруулж, дүгнэлтийг ёс зүйн дэд хорооны даргад танилцуулсан. Судалгаагаар нийтийн тээврийн жолоочийн аюулгүй байдал, хөдөлмөрийн нөхцөл хүнд байгааг харуулах бөгөөд зорчигчид ямар ч тохиолдолд жолоочоос хүлцэнгүй байдлыг шаардаж, тийм байгаагүй хүнийг ёс зүйгүй, бүдүүлэг гэж дүгнэдэг болох нь харагдаж байна. https://bus3.ub.gov.mn/?page_id=640	100%
5	Ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөө, тайланг олон нийтэд сурталчлах	Веб хуудсанд 10-аас доошгүй мэдээлэл оруулсан байх	Байгууллагын болон ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод сурталчилна.	100%	сайтад ёс зүйн дэд хорооны мэдээллийг тухай бүр байршуулсан. 1. Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, шинэчилсэн хувилбар, тушаал-4 2. Санал асуулгын хуудас-1 3. Дэд хорооны гишүүдийн холбоо барих утас 4. Хагас бүтэн жилийн тайлан-2	100%
6	Ажилчдын ёс зүйтэй холбоотой асуудлыг ажиллах журмын дагуу бүртгэж, ирүүлсэн материалыг шалгаж, дүгнэлт гаргах	Ирүүлсэн материалыг шалгаж ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар дүгнэлт гаргасан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн	100%	2023 оны жилийн эцсийн байдлаар үйлдвэрийн газрын "Ёс зүйн дэд хороо"-д өргөдөл гомдол 2 удаа ирж, зөвлөлийг хуралдуулж, гомдолд холбогдогчид ёс зүйн дүрмийн 4.2.1-д заасны дагуу "уучлал гуйх", 4.2.3 буюу хуулийн байгууллагаар шийдэгдэж байсан учраас асуудлыг тэр хэвээр нь үлдээх тус тус тогтоол гаргасан. Мөн цахим сүлжээнд тархсан бичлэгийн хүрээнд зөвлөлийг яаралтай хуралдуулж, даргын зөвлөлд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү асуудлын хүрээнд АТГ-ын мэргэжилтэн Д.Золжаргал "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль"-ийн танилцуулгыг	100%

1	2	3	4	5	6	7
			ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулна.		РРТ хэлбэрээр бэлтгэн цахимаар ирүүлж, хуулийн хүрээнд ажиллахыг зөвлөсөн. Шийдвэр бүхий зөвлөлийн тогтоолыг ажилтны хувийн хэрэгт тухай бүр хавсаргуулсан. Өргөдөл гомдлын хэлэлцүүлэг өмнөх оны мөн үеэс 2 дахин буурсан үзүүлэлттэй.	
7	Шинээр ажилд орж байгаа ажилчдад байгууллагад мөрдөгдөж байгаа дүрэм журмыг танилцуулж, тэмдэглэл хөтлөх	Ажилчид дүрэм, журамтай танилцсан байна.	Байгууллагын хэмжээнд мөрдөж буй дүрэм журмыг ажилчид мөрдөж ажиллана.	100%	Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд мөрдөж буй дүрэм журмыг шинээр ажилд орж буй 275 ажилтанд танилцуулсан.	100%
8	Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	Ёс зүйн зөвлөлийн жилийн тайланг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна	Зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт болон үйл ажиллагааг үнэлүүлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.	100%	1. "Ёс зүйн дэд хороо"-ны үйл ажиллагааны хагас бүтэн жилийн тайланг НЗДТГ-т хүргүүлсэн. 2. Нийтийн тээврийн салбарын тэргүүний ажилтан шалгаруулах номинацид нэр дэвшигч Тээвэрлэлт үйлчилгээний хэлтсийн гараж дугаар 3-144 тээврийн хэрэгслийн жолооч Хасбаатарын Доржпүрэвийн ёс зүйн байдлын судалгааг жолооч нарын ажлын гүйцэтгэл, Дотоод хяналт, шалгалтын хэлтсийн зөрчлийн мэдээ, ёс зүйн дэд хорооны тайлан, өргөдөл гомдлын мэдээлэлд үндэслэн, тодорхойлж ННТҮГ-т хүргүүлсэн. 3. "Ёс зүйн дэд хороо"-ны үйл ажиллагааны тайланг 2023 оны 12 сарын 20-ны байдлаар үйлдвэрийн газрын даргад танилцуулсан.	100%
Ерөнхий дундаж хувь						100%

ТАНИЛЦСАН: ДАРГА

О. ГАНБААТАР

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

А. 

Л. ОТГОНБААТАР

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М. ДОРЖХАНД